

## **МОНГОЛ, ВЬЕТНАМЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААГ ЭРЧИМЖҮҮЛЭХЭД АСЕАН, БНХАУ-ЫН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ АШИГЛАХ НЬ**

*Б.Гантуяа\**

Дэлхийн эдийн засаг улам бүр либералчлагдсаар байгаа өнөө үед, олон улсын худалдаанаас далайд гарцгүй, хөгжиж буй Монгол Улсын хүртэх ашгийг нэмэгдүүлэх, олон улсын бүс нутгийн хамтын ажиллагааны сүлжээнд болон бүс хоорондын интеграцийн эдийн засгийн бодлогод идэвхи санаачлагатай оролцох шаардлага нэгэнт бий болжээ, үүнд Монгол Улс аль бүс нутгаар дамжин эдийн засгийн илүү үр ашигтай байдлаар оролцох вэ гэсэн асуудал нэн чухал.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Ази-Номхон далайн бүсийн тэр дундаа Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улс орнуудтай тогтоосон улс төрийн харилцааг худалдаа, эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын агуулгаар баяжуулж, харилцаа, хамтын ажиллагааны агуулга, шинж чанар, зарчимд ихээхэн өөрчлөлтүүд гарч, эдийн засгийн хамтын ажиллагааны ашиглагдаагүй нөөц чадавхийг үзвэл харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж өргөн байна. Бүс нутгийн улс орнуудтай Монголын хөгжил дэвшилд бодит хувь нэмэр болохуйц, хэрэгжих боломжтой хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн бүхий л салбарыг хамарсан, жишээлбэл уул уурхай, банк санхүү, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, байгаль орчны хамгаалал, эрчим хүч, ойн аж ахуйн чиглэлүүдээр сонирхогч талуудын ашиг сонирхолд нийцсэн, харилцан ашигтай хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, судалгаа явуулах зэрэг бүс нутгийн улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хамтын арга замуудыг эрэлхийлэх шаардлага урган гарч байна. Тухайлбал, Монгол Улсын хөгжлийн ирээдүйтэй шууд холбогдох нэгэн чухал асуудал бол бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн асуудал юм. Монгол Улсын Баруун бүсээр дамжуулан ОХУ, БНХАУ, улмаар өрнө, дорнын орнуудтай холбосон дэд бүтцийн сүлжээг сайжруулах зорилгоор гадаад худалдаа - тээврийн хэд хэдэн цогцолборуудыг байгуулах олон талт хамтын төсөл, хөтөлбөрт Зүүн Азийн тэр дундаа Зүүн Өмнөд Азийн хөрөнгө оруулагчдыг “гурав дахь түнш”-ийн хэлбэрээр өргөнөөр татан оролцуулах боломжтой юм. Эдгээр олон талт төслүүдийг хэрэгжүүлэхэд “гурав дахь түнш”-ийн сонирхолын тэнцвэртэй байдлыг хадгалах үүднээс Монгол Улс урд хоёр хөрштэйгээ дамжин өнгөрөх (транзит) тээврийн хэлэлцээрийг өөрийн улсын онцлогт тохируулан, бүс нутгийн хэлэлцээртэй нийцүүлэн нэгдсэн сүлжээ болгон зохицуулах нь зүйтэй.

\* Б.Гантуяа - докторант

Зүүн Азийн бүсийн хамгийн том улс болох БНХАУ нь АСЕАН-ы гишүүн орон бус боловч 1997 оноос “АСЕАН+1” (АСЕАН+Хятад) нэрийн дор АСЕАН-ы гишүүн орнуудтай эдийн засгийн бүх талын хамтын ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлсээр байгаа бөгөөд одоо “АСЕАН+3” (АСЕАН+Хятад, АСЕАН+Солонгос, АСЕАН+Япон) хөтөлбөрийн хүрээнд идэвхтэй ажиллаж байна. БНХАУ-ын хувьд, АСЕАН-ы орнуудтай харилцаатай байх нь Зүүн Өмнөд Азид өөрийн байр суурь, ашиг сонирхлоо бэхжүүлэх, АСЕАН-ы гишүүн орнуудаас эдийн засгийн эх үүсвэрээ хангах, далайн худалдаагаа өргөтгөх зэрэг эдийн засгийн бодлого явуулан баримталж байна. АСЕАН-ы гишүүн орнуудын хувьд ч, БНХАУ-тай хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлийн холбоо тогтоох нь эдгээр улсуудын харилцаанд гарцаагүй хэрэгтэй зүйл билээ. 2010 онд АСЕАН+Хятадын худалдааны чөлөөт бүсийг байгуулах болсон явдал нь хоёр талын нягт хамтын ажиллагааг түргэсгэсэн, худалдааны цар хүрээг өргөтгөх өргөн боломж, нөөц бололцоог олгож байгаа төдийгүй Ази болон дэлхийн эдийн засгийн цаашдын тогтвортой хөгжилд идэвхтэй хувь нэмэр оруулах нь дамжиггүй. АСЕАН+Хятадын худалдааны чөлөөт бүсийг байгуулах үйл явц алхам алхмаар өргөжин тэлж эцсийн үе шатандаа орж буй энэ үед БНХАУ (2001 оны 12 сар) болон АСЕАН+Хятадын харилцааг хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж ирсэн БНСВУ (2006 оны 12 сар) хоёр улс орнууд ДХБ-т элссэн явдал АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмын ирээдүйн хөгжлийн харилцаанд шинэ түлхэц болж, Хятад, Вьетнам хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа хөгжлийн шинэ хүрээнд шилжин орсон.

Вьетнам улс ДХБ-д элссэнтэй холбогдуулж, Монгол, Вьетнам хоёр талын холбогдох байгууллагууд ДХБ-ын хүрээнд хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн холбогдох чиглэлээр хамтран ажиллах асуудлаар санал солилцох, шинэ цагийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, байр сууриа нэгтгэх, өмнө нь байгуулсан хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг шинэчлэн авч хэлэлцэх, худалдааны шинэ бодлого боловсруулах зэрэг асуудалд анхаарлаа хандуулах нь нэн шаардлагатай болоод байна. Монгол Улс, 1997 онд ДХБ-ын гишүүн болж, өнгөрсөн хугацаанд дэлхийн зах зээлд шудрагаар өрсөлдөн, багагүй туршлага хуримтлуулсан улс орны хувьд энэхүү давуу талаа дээд зэргээр ашиглан, ДХБ-д шинээр элссэн гишүүн орон болох Хятад болон Вьетнам хоёр улстай хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг харилцан нөхөх, бие биеэ түших зарчим дээр тулгуурласан бодлого явуулах, чөлөөт зах зээлийн тогтолцоонд нийцсэн эрх зүйн шинэтгэл хийх зэрэг ажлыг эхлүүлэх ёстой гэж үзнэ.

Монгол Улс, БНХАУ болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улс орнуудтай, тэр дундаа Зүүн Өмнөд Азийн интеграцлалын үйл явцыг

урагшлуулагч гол хүчин зүйл болсон БНСВУ-тай тогтоосон худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцааны өнөөгийн төлөв байдал, чиг хандлага нь АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмын хөгжлийн үйл явцад оролцох таатай хөрс суурь болж байна. Монгол Улсын эдийн засаг дэлхийн худалдаа, аж үйлдвэрийн гол цөм болон хувирч буй Хятад улсаар дамжин Зүүн Өмнөд Азийн эдийн засагтай гүнзгий интеграцчлагдан, тус бүсийн эдийн засагт эзлэх байр сууриа улам бататган бэхжүүлэх үйл явцад АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизм чухал ач холбогдол үзүүлэх хувилбар байж болох юм. Харин Монголын эдийн засгийг АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмын хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцоход түших орны нэг бол БНСВУ. Зүүн Өмнөд Азид Вьетнам улсын гүйцэтгэх үүрэг роль улам бүр өсөн нэмэгдсээр байна. Манай улс Вьетнам улстай олон жилийн уламжлалт харилцаатай бөгөөд олон талт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улс Вьетнам орны газар зүйн байршил, Ази-Номхон далайн бүс нутагт болон АСЕАН-ы бүс нутагт гүйцэтгэх үүрэг, эзлэх чухал байр суурийн хувьд стратегийн гол түншээ болгосон.

Сүүлийн жилүүдэд Монгол, Вьетнам хоёр орны гадаад худалдааны тоон үзүүлэлтэд ихээхэн ахиц өөрчлөлт гарсан байна. 2006 онд 2970,0 сая ам.долларт хүрч байсан хоёр орны худалдааны эргэлтийн хэмжээ 2007 онд 6644 сая ам.доллар болон өсөн нэмэгдлээ. Энэ нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны удаан жилээр сунжран яригдаж буй шийдлээ хүлээж байсан асуудлуудыг шийдвэрлэхэд зарчмын нааштай ахиц гарсантай ямар нэгэн хэмжээгээр холбоотой юм. Гэвч хоёр орны гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээ өссөн хэдий ч 2006 онд худалдааны алдагдал 3 сая орчим ам.доллар байсан бол, 2008 онд 8 сая ам.долларт хүрэв. Иймд, хоёр орны гадаад худалдааны нийт эргэлт ахицтай боловч хоёр орны худалдаа Монгол Улсын нийт гадаад худалдааны 0,2 хувийг эзэлж байгаа нь Монгол, Вьетнам хоёр улсын хамтын ажиллагааны ирээдүй хэдийгээр өөдрөг төсөөлөлтэй байгаа ч өнөөг хүртэл хүсч хүлээж байгаа түвшинд хүрээгүй хэвээр байна. Цаашид харилцан ашигтай хөрөнгө оруулалт, худалдааг хөгжүүлэх өргөн нөөц боломж байгаа бөгөөд ойрын хугацаанд өмнөх түвшингээс ч өсөх магадлал өндөр байна. Хоёр тал эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр өөр өөрийн экспортын давуу талаа ашиглаж, харилцан нийлүүлэх экспортын гол бараа бүтээгдэхүүний бүтэц болон хэмжээ тоог улам өргөжүүлэн хөгжүүлснээр худалдааг тодорхой үр дүнд хүргэж чадна.

БНСВУ нь манай улсын хөрөнгө оруулалтын харьцангуй шинэ түнш. Вьетнам улсын хөрөнгө оруулагчид 90-ээд оны сүүлээс Монголд

хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд Вьетнамаас хийгдэж буй хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой өсөн нэмэгдэж байна. Вьетнамын хувийн хэвшлийн зүгээс уул уурхай, барилга, эрчим хүч, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуй (мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэл), аялал жуулчлал (зочид буудал, жуулчны бааз байгуулах болон түүний менежментийг дээшлүүлэх) зэрэг салбаруудаар хөрөнгө оруулалт хийх, хамтарч ажиллах сонирхол нэмэгдэж байна. Оновчтой бодлого, уян хатан үйл ажиллагаа, аль аль талын боломж, сонирхол зэргийг бодлогодоо тусгаж, шинэлэг санаа арга барилаар идэвхтэй ажиллаж системчлэн хөгжүүлж чадвал улсын эдийн засагт илүү үр ашигтай, мөн хоёр орны бүх талын харилцаа, хамтын ажиллагаа өмнөх жилүүдээс илүү эрчимтэй хөгжих болно.

Монгол Улс, АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмаар дамжин, БНХАУ болон Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улс орнуудтай хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцан шүтэлцээ бүхий хамтын ажиллагааны сүлжээг бий болгох, үүнд хамтын ажиллагааны харьцангуй давуу талыг өөртөө ашигтайгаар эргүүлж харилцан ашигтай тал болгон хувиргах зэрэг асуудал дээр анхаарч ажиллах нь зүйтэй. Цаашилбал, Хятадын газар нутгаар дамжин Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн улс орнуудад экспорт, импортын бараа бүтээгдэхүүн тээвэрлэх шинэ гарц бий болгох чиглэлээр АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмын хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцох замаар Монгол - АСЕАН+Хятадын хоорондох гурван талт хамтын ажиллагааны яриа хэлэлцээрийг өрнүүлэх боломж ч байж болно.

Иймд, Хятад улс болон АСЕАН-ы бүс нутгийн улс орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмын үйл ажиллагаа, АСЕАН-ы бүс нутгийн улс орны эдийн засагт БНХАУ-ын зүгээс үзүүлэх эдийн засгийн нөлөө, хүчин зүйлсийн төлөв байдлыг судлах, АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмыг Монгол Улсын “гурав дахь түнш”-ийн нэг нь болгох боломжийг авч үзэх, тэдний зүгээс эдийн засгийн бодит сонирхлыг Монголд бий болгох талаар эрэлхийлэн ажиллах, АСЕАН+Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны механизмаар дамжин, Монгол, Вьетнам хоёр улсын хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, харилцаа холбоог эрчимжүүлэх арга замыг тодорхойлох, эдгээр улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хүчин зүйл, түүний нөлөөллийг судлах хэрэгтэй гэж үзнэ.